

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2018 оны 03 дугаар сарын 30-ны өдөр

ОРШИЛ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2017 оны үйл ажиллагааны үнэлгээг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, “Бодлогын баримт бичиг, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7 дугаар хавсралтад заасан хүснэгтийн дагуу 3 багц, 10 үзүүлэлтээр дүгнэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ, яамны чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээний үзүүлэлтийн хүрээнд Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зэрэг бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуйн салбарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилт, яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ болон 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар тусгасан зорилтын биелэлт, ил тод байдлын үнэлгээ, яамны хэрэглэгчийн үнэлгээ, Үндэсний статистикийн хорооноос гаргасан Монгол улсын нийгэм, эдийн засгийн байдал 2017 оны эмхэтгэл, 2017 оны 12 сар, Хөдөө аж ахуй 2017 эмхэтгэл, Гаалийн ерөнхий газраас гаргасан Гадаад худалдааны барааны статистик 2017/12 болон гүйцэтгэлийн үр дүнг нотлох холбогдох материалууд, хэрэгжүүлэгч газруудаас тодруулга авах замаар цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэв.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн биелэлтийн 2017 онд хүрсэн бодит үр дүнг хүрвэл зохих үр дүнгийн түвшинтэй харьцуулан хувиар тодорхойлж үнэлгээг гаргав.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2017 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээ **86.3** хувь буюу **4.3** оноотой байна.

1. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ


1.1. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ, ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ (2017 оны жилийн эцсийн байдлаар)

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд 2017 оны жилийн эцсийн байдлаар ЗГХЭГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний албан ёсны цахим хуудсанд байршуулсан нийт 104 тогтоол, шийдвэрийн 198 заалтаас ХХААХҮЯ-ны үндсэн чиг үүрэгт хамаатай Монгол Улсын хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, Улсын Их Хурал, УИХ-ын Байнгын Хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, тэмдэглэл нийлсэн нийт 104 тогтоол, шийдвэрийн 198 заалтыг хяналтад авч журмын заалтуудыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

1.1.1. Үнэлгээний дундаж дүн

Хяналт-шинжилгээ үнэлгээний дүнг тайлангийн хавсралтын нэгдүгээр хүснэгтэд үзүүлэв. Нэгдүгээр хүснэгтээс харахад хяналтад авсан 198 заалтын 101 (51.0 хувь) нь бүрэн биелэгдсэн, 73 (36.8 хувь) заалт хэрэгжилтийн шатанд, 23 (11.6 хувь) заалт хэрэгжилт хангалтгүй, хугацаа болоогүй, хэрэгжээгүй заалт байхгүй ба биелэлтийн дүн дунджаар 81.7 хувьтай үнэлэгдэв. Хугацаа болоогүй 4 заалт, ХХААХҮ-ийн сайдын эрхлэх асуудлын үндсэн чиг үүрэгт хамааралгүй 2 заалт байна.

Нийт 104 тогтоол, шийдвэрийн хяналтад авсан 198 заалтын хэдэн заалт нь аль шийдвэрт хамаарч байгааг нэгдүгээр график зурагт үзүүлэв.



Бүдүүвч 1-д үзүүлсэн тогтоол, шийдвэрийн заалтуудыг нарийвчлан авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- **Монгол Улсын Хуулийн** хяналтад авсан 9 хуулийн 19 заалт хяналтад авсны 5 заалт бүрэн хэрэгжсэн (100 хувь), 8 заалт хэрэгжих шатанд (70 хувь), 6 заалт хэрэгжилт хангалтгүй (30 хувь) тус тус үнэлэгдэж, биелэлтийн дундаж **65.3** хувьтай,

- **Улсын Их Хурлын тогтоолын** хяналтад авсан 7 тогтоолын 11 заалт хяналтад авсны 3 заалт бүрэн хэрэгжиж (100хувь), 7 заалт хэрэгжих шатанд (70 хувь), 1 заалт хэрэгжилт хангалтгүй (30 хувь) тус тус үнэлэгдэж, биелэлтийн дундаж **74.5** хувьтай,

- **Улсын Их Хурлын Байнгын Хорооны тогтоолын** хяналтад авсан 3 тогтоолын 8 заалт хяналтад авсны 4 заалт бүрэн хэрэгжсэн (100 хувь), 3 заалт хэрэгжих шатанд (70 хувь), 1 заалт дүгнэгдээгүй, биелэлтийн дундаж 87.1 хувьтай,

- **Ерөнхийлөгчийн зарлигийн** хяналтад авсан 5 зарлигийн 11 заалт хяналтад авсны 6 заалт бүрэн хэрэгжсэн (100хувь), 2 заалт хэрэгжих шатанд (70 хувь), 3 заалт хэрэгжилт хангалтгүй (30 хувь), 1 заалт хугацаа болоогүйгээр тус тус үнэлэгдэж, биелэлтийн дундаж **80.0** хувьтай,

- **Засгийн газрын тогтоолын** хяналтад авсан 36 тогтоолын 59 заалт хяналтад авсны 32 заалт бүрэн хэрэгжсэн (100хувь), 19 заалт хэрэгжих шатанд (70 хувь), 7 заалт хэрэгжилт хангалтгүй (30 хувь), 1 заалт хугацаа болоогүйгээр тус тус үнэлэгдэж, биелэлтийн дундаж **81.4** хувьтай,

- **Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн** хяналтад авсан 39 тэмдэглэлийн 70 заалт хяналтад авсны 38 заалт бүрэн хэрэгжсэн (100 хувь), 27 заалт хэрэгжих шатанд (70 хувь), 2 заалт хэрэгжилт хангалтгүй (30 хувь), 2 заалт хугацаа болоогүй, 1 заалт дүгнэгдээгүй бөгөөд биелэлтийн дундаж **85.9** хувьтай,

- **Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж** хяналтад авсан 3 зөвлөмжийн 8 заалт хяналтад авсны 2 заалт бүрэн хэрэгжсэн (100хувь), 5 заалт хэрэгжих шатанд (70 хувь), 1 заалт хэрэгжилт хангалтгүй (30 хувь) тус тус үнэлэгдэж, биелэлтийн дундаж **72.5** хувьтай,

- **Засгийн газрын албан даалгаврын** хяналтад авсан 1 даалгаврын 11 заалтыг хяналтанд авсан нь бүрэн хэрэгжиж **100.0** хувь,

- **Засгийн сайдын захирамжийн** хяналтад авсан 1 захирамжийн 1 заалтыг хяналтанд авсан нь **70** хувийн биелэлттэй байна.

1.1.2. Дүгнэлт

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт холбогдох хууль тогтоомж, засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн явцад хийсэн үнэлгээний дундаж дүн 81.7 хувьтай, үүнээс Засгийн газрын албан даалгаврын биелэлт хамгийн өндөр буюу 100 хувь, Монгол улсын хууль хамгийн бага 65.3 хувийн биелэлттэй байна. Өөрөөр хэлбэл, цаг хугацааг тодорхой заасан, богино хугацаанд хэрэгжих шийдвэрийн биелэлт өндөр байна.


2. Салбарт холбогдох хууль тогтоомж, засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн явцад 7хийсэн үнэлгээний ажлын үр дүнд Монгол Улсын хуулийн 2, Улсын Их Хурлын тогтоолын 1, УИХ-ын Байнгын Хорооны тогтоолын 3, Ерөнхийлөгчийн зарлигийн 2, Засгийн газрын тогтоолын 14, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 20 зэрэг нийт 42 шийдвэрийн 54 заалтыг хяналтад авсан тооноос хасуулах шаардлагатай гэж үзэв.

3. Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн үр дүнг тайлагнах, мэдээлэл солилцох, харьяа байгууллагууд болон яамны бүтцийн нэгж хоорондын хамтын ажиллагаа сайжирч, ажлын дотоод зохион байгуулалт дээшилж байна.

4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжүүлэхээр хяналтад авсан заалтуудаас 24.2 хувь нь 2016 оноос өмнө батлагдаж 75 хувийн биелэлттэй, 27.3 хувь нь 2016 онд батлагдаж 80.8 хувийн биелэлттэй, 48.5 хувь нь 2017 онд шинээр батлагдсан бөгөөд 85.1 хувийн биелэлттэй байна. Тодруулбал шинээр гарсан тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа харьцангуй шуурхай зохион байгуулагдаж байгаа нь хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн явц, үр дүнгээс харагдаж байна.

Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хяналтад авсан заалтуудыг батлагдсан он, нийт шийдвэрт эзлэх хувь болон биелэлтийг хоёрдугаар график зурагт үзүүлэв

Бүдүүвч 2



1.1.3. Зөвлөмж

1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт холбогдох хууль тогтоомж, засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн явцад хийсэн үнэлгээний дундаж дүнгээс үзэхэд Монгол Улсын хууль, Ерөнхий сайдын захирамж, УАБЗ-ийн зөвлөмжийн биелэлтэд улирал бүр хяналт тавьж үр дүнг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг яамны Бодлого төлөвлөлтийн газар болон Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газруудад,

2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцын дундаж дүнтэй (81.7 хувь) өөрсдийн салбар болон газрын биелэлтийн дундаж үнэлгээг харьцуулан аль түвшинд хэрэгжиж байгаад дүн шинжилгээ хийж ажиллахыг,

3.ХХААХҮ-ийн сайдын А-159 дүгээр тушаалаар батлагдсан “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлан ажиллах. Тус аргачлалын дагуу тайлагналтыг сайжруулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах шаардлагатай. Тухайлбал нэг ажлыг хэд хэдэн заалтын биелэлтэд тайлагнах, тухайн заалтад хамааралгүй биелэлт гаргах, хэт нурших зэрэг нийтлэг алдаа дутагдлыг дараа дараагийн тайланд засаж сайжруулахыг харьяа байгууллагууд болон яамны бүтцийн нэгжүүдэд тус тус зөвлөмж болгож байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт холбогдох хууль тогтоомж, засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн явцад хийсэн үнэлгээ (2017 оны жилийн эцсийн байдлаар)

Үзүүлэлт	Бүгд	Шийдвэрийн төрлөөр								
		Монгол улсын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны гэмдэглэл	ЗГ-ын албан даалгавар	Ерөнхий сайдын захирамж	УАБЗ-ийн зөвлөмж
Хяналтанд авсан тогтоол шийдвэрийн тоо	104	9	7	3	5	36	39	1	1	3
Заалт	198	19	11	8	11	59	70	11	1	8
Үнэлгээ	Биелсэн 100.0%	101	5	3	4	6	32	38	11	2
	Хэрэгжих шатанд: 70%	72	8	7	3	2	19	27		5
	Хэрэгжилт хангалтгүй 30%	19	6	1		2	7	2		1
	Хэрэгжээгүй 0 %	0								
	Хугацаа болоогүй	4				1	1	2		
	Дүгнэгдээгүй	2			1	-		1		
Үнэлгээ	81.7	65.3	74.5	87.1	80.0	81.4	85.9	100	70.0	72.5

1.2. ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ (2017 оны жилийн эцсийн байдлаар)

Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /цаашид ХХААХҮЯ гэх/ дангаар болон толгойлон хэрэгжүүлэхээр тусгагдсан 62 зорилтын 160 арга хэмжээг хяналтад авч хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Эдгээр зорилт, арга хэмжээг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудалд хамаарах Засгийн газрын агентлаг, харьяа байгууллагууд болон яамны нэгж, газрын тухайн жилийн төлөвлөгөө, холбогдох албан хаагчийн үр дүнгийн гэрээнд тусган хэрэгжүүлэх, хэрэгжилтийн явцын мэдээллийг яамны Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүллээ. Нийт арга хэмжээнээс 2017 оны жилийн эцсийн байдлаар 3 арга хэмжээ 50 хувь, 48 арга хэмжээ 30 хувь, 84 арга хэмжээ 10 хувийн биелэлттэй байна. Харин 22 арга хэмжээг үнэлэх хугацаа болоогүй, 3 арга хэмжээг үнэлэх боломжгүй байлаа. Тус салбарын хяналтад авсан арга хэмжээнүүдийн хэрэгжилт дунджаар 18.0 хувь байгаа нь 2017 онд хүрвэл зохих түвшинг хангалттай биелүүлсэн байна. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн биелэлтийг бодлогын зорилтоор нь авч үзвэл Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлогын хүрээнд төлөвлөгдсөн 2 зорилтын 2 арга хэмжээний биелэлт дунджаар 20.0 хувь, Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлогыг хүрээнд 43 зорилтын 130 арга хэмжээний биелэлт дунджаар 18.1 хувь, Нийгмийн бодлогын хүрээнд 3 зорилтын 5 арга хэмжээний биелэлт дунджаар 23.3 хувийн биелэлттэй дүгнэгдлээ. Харин аймаг, орон нутгийн талаар тусгайлан оруулсан 23 заалтын 15 нь үнэлэгдээгүй бол үнэлэгдсэн 8 заалтын хэрэгжилт хамгийн бага буюу дунджаар 10.0 хувь байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн дээр тулгуурлан дараагийн шатны төлөвлөлт, тайлагналтыг сайжруулах талаар зөвлөмж боловсруулж тус яамны холбогдох албан тушаалтанд хүргүүлэн ажиллаж байгаа болно.

1.2.1. Арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ

Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам дангаар болон хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан 64 зорилтын 172 арга хэмжээг хяналтад авч хэрэгжилтийг ханган ажилласан. Эдгээрээс 164 арга хэмжээ Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим мэдээллийн санд бүртгэгдсэн байна.

Төлөвлөгдсөн нийт арга хэмжээнээс 2017 оны жилийн эцсийн байдлаар 5 арга хэмжээ 100 хувь, 29 арга хэмжээ 70 хувь, 72 арга хэмжээ 40 хувь, 40 арга хэмжээ “0” хувийн биелэлттэй байна. Үүнээс гадна 18 арга хэмжээг үнэлэх боломжгүй байна. Үнэлэх боломжгүй арга хэмжээнүүд нь яамны төлөвлөгөө батлагдсанаас хойш хяналтад авсан, төсөв хөрөнгө тодорхойгүй, гүйцэтгэлийг үнэлэхэд хангалттай мэдээлэл байхгүй зэрэг гадаад хүчин зүйлээс хамаарсан шалтгаантай байв. Тус салбарын хяналтад авсан арга хэмжээний хэрэгжилт дунджаар 37.05 % байгаа тул 2017 оны жилийн эцэст хүрвэл зохих түвшинг “хангалттай” буюу 98.8 %-иар биелүүлсэн гэж дүгнэж байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгийн товчоо

	2016 оны жилийн эцэс	2017 оны хагас жил	2017 оны жилийн эцэс
Нийт	160	164	164
100%	0	0	5
70%	3 (50%)	6	30
40%	48 (30%)	68	76
0%	84 (10%)	55	40
ҮБгүй	3	35	21
Дундаж	18.00%	24.34%	37.05%
Зорилтот түвшин	15.00%	25.00%	37.5%
Биелэлт	100%	97.40%	98.8%

1.2.2. Дүгнэлт

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд ХХААХҮ-ийн салбарт хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт 2017 оны жилийн эцсийн байдлаар 37.05 (98.8) хувь байна.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд аймаг, орон нутгийн талаар тусгайлан оруулсан заалтуудыг хэрэгжүүлэх бэлтгэл

ажил хангагдаагүй, төсөв хөрөнгө шийдвэрлэгдээгүй байгаа нь хэрэгжилт удаашрах нөхцөл байдал үүсгэж байгаа тул эдгээр ажлыг эрчимжүүлэх талаар Засгийн газрын хэрэг эрх газар бусад яамдтай хамтран тусгайлсан хэлэлцүүлэг зохион байгуулах шаардлагатай байна.

1.2.3. Зөвлөмж

1. Өнөөгийн байдлаар мал аж ахуйн салбарт “Монгол мал” хөтөлбөр, “Төрөөс Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”, “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого” хэрэгжиж байгаа бол шинээр “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийг боловсруулан батлуулахаар бэлтгэж байна. Эдгээр бодлогын баримт бичгүүдийн давхардал, хийдэлд тусгайлсан дүн шинжилгээ хийх хэрэгцээ, шаардлага гарч байна. Тухайлбал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан “Монгол малчин”, “Малжуулах”, “Малчдыг мэдлэгжүүлэх” хөтөлбөрийг нэгтгэн боловсруулах тухай Сангийн яамны саналыг дэмжин ажиллах хэрэгтэй байна.

2. Хөтөлбөрийн 2.43-ын 1 дэх хэсгийн Хайгуул судалгаа, хийгдсэн бүсүүд, томоохон голуудын сав газарт урсацын тохируулга хийж, ус хуримтлуулах, усан сан бүхий томоохон услалтын системийн барилга барих, усыг талбайд хүргэх гол суваг, талбай хоорондын ус хуваарилах сүлжээний барилга байгууламж барих арга хэмжээний хүрээнд шаардлагатай журам, стандарт, техникийн баримт бичгүүдийг яаралтай боловсруулах шаардлагатай.

3. Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Монгол Улсын үйлдвэржилтийн газрын зургийг экосистем, хүн амын нутагшил, суурьшил, түүхий эдийн нөөц, дэд бүтцийн бодлоготой уялдуулан гаргах арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажлын үр дүн хангалтгүй байгаа тул эрчимжүүлэх.

4. Хөтөлбөрийн 2.9-ын 1 дэх хэсгийн үйлдвэрлэлд ашиглагддаг уур, ус, дулаан, цахилгааны тарифыг тогтвортой байлгах, бууруулах замаар бүтээгдэхүүний өртгийг багасгах бодлого хэрэгжүүлэх гэсэн арга хэмжээ үр дүнгүй байна. Иймээс үйлдвэрлэл дэх ус, уур, дулаан цахилгааны өртгийг багасгах бодлого боловсруулж хэрэгжүүлэх чиглэлээр салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах хэрэгтэй.

5. Төлөвлөгөөний 2.54-ын 1 дэх хэсгийн технологий дамжуулалт, зөвлөгөө мэдээллээр үйлчилсэн 1 гэрээт ажил хийгдэж, технологи нутагшуулах нөхцөл бүрдэх гэсэн үр дүнгийн үзүүлэлт хангалтгүй байна. Хөнгөн үйлдвэрийн салбарт тэргүүний дэвшилтэт технологи дамжуулах, нэвтрүүлэх ажилд ахиц дэвшил гаргахын тулд хувийн хэвшлийн байгууллагаар төрийн зарим үүргийг гүйцэтгүүлэх, санхүүгийн болон эрх зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажиллах хэрэгтэй байна.

6. УИХ-ын 2012 оны “Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын хангах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоолд заасан батлуулаагүй журам, дүрэм зааврын төсөл, “Эрүүл хүнс-эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулах, батлуулах ажлыг эрчимжүүлж, 2018 оны жилийн эхнээс хяналтад авч, улирал бүр тайлагнаж байх хэрэгтэй байна.

7. “Сав баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн хэрэгжлтийг эрчимжүүлэх, шаардлагатай санхүүжилтийг төсөвт тусгуулах, “Үдийн цай” хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн ЕБС-ийн бага ангийн сурагчдад өдөр бүр өгөх сүү, сүүн бүтээгдэхүүнийн хэмжээг 200 граммд хүргэх замаар бага насны хүүхдийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх хэрэгтэй.

8. Хөтөлбөрийн 2.21-ын 1; 2.23-ын 4, 5, 7; 2.24-ын 1; 2.28-ын 1; 2.32-ын 4, 7; 2.33-ын 3; 2.39-ын 5; 2.43-ын 1; 2.51-ын 1; 2.52-ын 1, 2; 2.53-ын 3; 2.54-ын 1; 2.55-ын 1; 2.56-ын 1, 2; 2.57-ын 1; 2.58-ын 1-д заасны дагуу хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тайланг хэтэрхий дэлгэрэнгүй гаргаж ирүүлсний улмаас Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим мэдээллийн санд олон тооны хавсралт оруулах шаардлага гарч байгаа тул эдгээр арга хэмжээний зөвхөн үр дүнг тайлагнаж байх хэрэгтэй байна.

1.3. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ (2017 оны жилийн эцсийн байдлаар)

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын 2016 оны 70 дугаар тогтоолд тусгаснаар Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлогын хүрээнд Мал аж ахуй, газар тариалангийн салбарын үйлдвэрлэлийг дэмжиж, бүтээгдэхүүний гарц, ашиг шимийг нэмэгдүүлэх, Хүнс, хөнгөн,

жигжиг, дунд үйлдвэрлэлийн салбарын хөгжлийг эрчимжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилт бүхий 18 арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээний зорилго нь үндсэн чиглэлийн зорилт, үйл ажиллагааны гүйцэтгэлийг хүлээгдэж буй үр дүнд хүрч байгаа эсэхийг тогтоох, арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудад мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

1.3.1 Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний товчоо (арга хэмжээгээр)

Зорилт	Зорилт	Арга хэмжээ	Явцын үнэлгээ			Арга хэмжээний биелэлт, жилийн эцсийн байдлаар, хувиар					аж үн элг
			Улирал			100	70	40	0	(-)	
			I	II	III						
- Мал аж ахуй, газар тариалангийн салбарын үйлдвэрлэлийг дэмжиж, бүтээгдэхүүний гарц, ашиг шимийг нэмэгдүүлэх; -Хүнс, хөнгөн, жигжиг, дунд үйлдвэрлэлийн салбарын хөгжлийг эрчимжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх	2	18	25.0	41.1	57.8	8	4	6	0	0	73.3

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах арга хэмжээний гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн 2017 оны жилийн байдлаар 73.3 хувьтай үнэлэгдэв. Үүнд, есөн арга хэмжээ “үр дүнтэй”, гурван нь “тодорхой үр дүнд хүрсэн”, зургаан нь “эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлсэн байна. “Үр дүнгүй” эсвэл “үнэлэх боломжгүй” хэмээн үнэлэгдсэн арга хэмжээ байхгүй.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний товчоо (салбараар)

	2017	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар					
		БТГ	МААБХЗГ	ГТБХЗГ	ХөҮБХЗГ	ЖДҮХБХЗГ	ХҮҮБХЗГ
Нийт	18	5	5	4	2	1	1
“үр дүнтэй” (100%)	8	1	2	2	1	1	1
тодорхой үр дүнд хүрсэн (70%)	4	2	1	1	-	-	-
эрчимжүүлэх шаардлагатай (40%)	6	2	2	1	1	-	-
үр дүнгүй (0%)	-	-	-	-	-	-	-
“үнэлэх боломжгүй”	-	-	-	-	-	-	-
Үнэлгээ	73.3	64.0	70.0	77.5	70.0	100	100

Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг салбар бүрээр авч үзвэл Бодлого төлөвлөлтийн газар 6 арга хэмжээг 64.0, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 5 арга хэмжээг 70.0, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 3 арга хэмжээг 77.5, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 1 арга хэмжээг 70.0, Жигжиг дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 1 арга хэмжээг 100.0, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 1 арга хэмжээг 100.0 хувийн гүйцэтгэлтэйгээр тус тус хэрэгжүүлсэн байна.

1.3.2. Дүгнэлт

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах арга хэмжээний гүйцэтгэл 2017 оны жилийн эцсийн байдлаар 73.3 хувьтай үнэлэгдэв.

2. Үндсэн чиглэлд тусгагдсан 18 зорилт, арга хэмжээний хэрэгжилт I улиралд 25.0 хувь буюу зохих түвшиндээ хүрсэн хэдий ч II – IV улиралд жигд 15.5-17.2 хувийн өсөлттэй байсан нь жилийн эцсийн үнэлгээ 73.3 хувиар үнэлэхэд нөлөөлсөн.

3. Төлөвлөгдсөн 18 арга хэмжээнээс 8 нь 100 хувь, 4 нь 70 хувь, 6 нь 40 хувь хэрэгжилттэй байна.

4. БТГ - 5 ажлыг 64.0, МААБХЗГ - 5 ажлыг 70.0, ГТБХЗГ- 4 ажлыг 77.5, ХөҮБХЗГ- 2 ажлыг 70.0, ЖДҮХБХЗГ - 1 ажлыг 100.0, ХүҮБХЗГ – 1 ажлыг 100.0 хувийн үнэлгээтэйгээр гүйцэтгэсэн байна.

5. “Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 40 хувийн гүйцэтгэлтэй арга хэмжээнүүдийн шалтгаан нөхцлийг судалж үзэхэд нэг жилийн хугацаанд цаг хугацааны хувьд хэрэгжүүлэх боломжгүй, санхүүжилт шийдэгдээгүй, гадаад хүчин зүйлсээс нөлөөлсөн, удирдлага, зохион байгуулалт, газар хоорондын ажлын уялдаа холбооноос шалтгаалж байв.

1.3.3. Зөвлөмж

1. 2019 оны Үндсэн чиглэлийг төлөвлөхдөө :

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоол, “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын

- 48.1-д “төлөвлөсөн арга хэмжээ нь тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай байх”

- 48.2-т “... арга хэмжээ бүрт шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр нь үндэслэлтэй, бодитой, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн байх” гэсэн заалттай уялдуулж, цаг хугацаа, хүний нөөц, хөрөнгийг зөв тооцож, бодитой төлөвлөх;

2. 2018 оны Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхдээ:

- Оны эхнээс холбогдох зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, тайлагналтын ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А-159 дүгээр тушаалаар баталсан “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал” –ын дагуу боловсруулах, тайлагналтыг сайжруулах.

1.4 ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

№	Үзүүлэлт	Суурь үзүүлэлт 2016	Зорилтот түвшин 2017	Хүрсэн түвшин	Үнэлгээ	Зөрүү
1	Хөдөө аж ахуйн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүний эзлэх хувь	12.0	12.5	10.6	84.8	- 1.9
2	Аж үйлдвэрийн салбарын бүтцэд хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэлийн эзлэх хувь	10.6	11.0	9.2	83.6	- 1.8
3	Аж үйлдвэрийн салбарын бүтцэд хөнгөн үйлдвэрийн эзлэх хувь	7.2	7.4	7.5	100.0	+ 0.1
4	ДНБ-ийн үйлдвэрлэлд худалдаа, нийтийн хоол, ахуйн үйлчилгээний салбарын эзлэх хувь	17.3	17.4	17.9	100.0	+ 0.5
5	Нийт экспортод боловсруулах үйлдвэрийн эзлэх хувь	14.0	14.3	15.5	100.0	+ 1.2
6	Монгол Улсын нийт төсөвт хүнс, хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь	2.0	2.3	2.2	95.6	- 0.1
7	Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах, мянган тонн	16.8	24.5	24.5	100.0	0
8	Нийт сүү үйлдвэрлэлд эзлэх үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний эзлэх хувь	9.0	10.2	9.7	95.0	- 0.5
9	Нийт сүрэгт эзлэх үхрийн хувь	6.7	7.0	6.6	94.3	- 0.4
10	Тариалангийн эргэлтийн талбай, мянган га	885.0	915.0	890.4	97.3	- 24.6
11	Хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээс хангах түвшин, хувь	54.0	60.0	47.7	79.5	-12.6
12	ХАА-н салбарт ажиллагсдын тооны өөрчлөлт (мянга, IV улирал)	352	365	379.8	100.0	+ 14.8
13	Хоршооны тоо (мянга)	4.3	4.5	4.4	97.8	- 0.1
14	Хүнсний салбарт ажиллагсдын тооны өөрчлөлт (мянга, IV улирал)	13.5	13.6	17.4	100.0	+ 3.8
15	Хөнгөн үйлдвэрийн салбарт ажиллагсдын тооны өөрчлөлт (мянга, IV улирал)	50.9	51.4	69.7	100.0	+ 18.3
	Дундаж үнэлгээ	-	-	-	89.5	-

2. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

2.1 Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

Тус яамнаас 2017 онд стратегийн 8 зорилтын хүрээнд 191 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлсэн ба төлөвлөгөөний биелэлт, үр дүнгийн хүрсэн түвшинд үндэслэн хийсэн үнэлгээгээр гүйцэтгэл **68.5** хувьтай дүгнэгдэв. Тайлант хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үйл ажиллагаа нь урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдсан байдал харьцангуй сайн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

Стратегийн зорилт, үйл ажиллагаа	Арга хэмжээний тоо	Үнэлгээ, хувь
Стратегийн зорилт 1. Сайдын эрхлэх асуудлын хүрээний хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөр болон шийдвэрийн төслийг боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, эрх зүйн мэргэшил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, цаг үеэ олсон бодлогын зөвлөгөө өгөх, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв, санхүүг төлөвлөх, хэрэгжүүлэх;	51	63.0
Стратегийн зорилт 2. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагаар хангах, аппаратын дотоод зохицуулалт, үйлчилгээг эрхлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх;	28	77.8
Стратегийн зорилт 3. Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;	16	61.9
Стратегийн зорилт 4. Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;	28	67.5
Стратегийн зорилт 5. хөнгөн үйлдвэр, дотоод худалдаа, нийтийн хоол, үйлчилгээний бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;	15	58.0
Стратегийн зорилт 6. Хүнсний үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;	16	70.6
Стратегийн зорилт 7. жижиг, дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;	18	64.4
Стратегийн зорилт 8. Салбарын бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дотоодын аудит хийх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах;	19	85.6
Дундаж үнэлгээ	191	68,5

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2017 оны үйл ажиллагааны тайланг хавсралтаар хүргүүлсэн болно.

2.2. Байгууллагын хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт

1. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд нийт албан хаагчдаас судалгааг авч, гаргасан саналыг “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-т тусган боловсруулав. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн үйл ажиллагааны 2017 оны төлөвлөгөөг баталж, 4 зорилтын хүрээнд 18 төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэв.

- Яамны “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг үндэслэн 20 албан хаагчид мөнгөн тусламж, дэмжлэг үзүүлж нийт 2 560 000 төгрөг, яамны 4 өндөр настны ар гэрт нийт 250 000 төгрөгийн мөнгөн тусламж өгсөн.

-Хүүхдийн баярыг яамны албан хаагчдын болон үйлчилгээний албан хаагчдын нийт 164 хүүхдэд баярын мэндчилгээ дэвшүүлж бэлэг гардуулав.

-Гэрт буюу галладаг сууцанд амьдардаг 12 албан хаагчид өвлийн улиралд түлшний зардалд тус бүр 200 000 төгрөгийн мөнгөн тусламж олгов.

-“Эрүүл агаар-Эрч хүч” өдөрлөг 2017 оны 03 сарын 17-ны өдөр зохион байгууллаа. “Ази фарм” ХХК-тай хамтарч “Хаврын витаминжуулалт” өдөрлөг зохион байгуулж албан хаагчдын сахарыг хэмжих, ясны сийрэгжилтийг тодорхойлох, нарийн мэргэжлийн эмчийн үзлэг зөвлөгөө өгөх, витамин танилцуулга зэрэг үйлчилгээг хийлээ. Нийт 57 албан хаагч хамрагдсан байна.

-Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг 2017 оны 10 сарын 12-20-ны өдрүүдэд Улсын хоёрдугаар төв эмнэлэгтэй хамтран зохион байгуулж нийт 122 албан хаагчийг үзлэгт хамруулж, 27 албан хаагч эмнэлэгт хэвтэн болон өдрийн эмчилгээнд хамрагджээ. Эмэгтэйчүүдийн эмчтэй хамтран 4 төрлийн үзлэг шинжилгээнд эмэгтэй албан хаагчдыг хамруулах ажлыг зохион байгуулсан.

- Ажлын байрны өнгө үзэмжийг сайжруулах, албан хаагчдын ая тухтай, эрүүл орчинд ажиллах нөхцөл бүрдүүлэх, экологийн мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор ажлын өрөө тасалгааг цэцэгжүүлэх ХХААХҮ-ийн сайдын нэрэмжит “Ногоон орчин” уралдааныг яамны газар, хэлтэс харьяа байгууллагын дунд 2017 оны 04 сарын 07-ны өдрөөс 2017 оны 05 сарын 18-ны өдрүүдэд зарлаж, шалгаруулалтыг хийсэн.

- Төрийн захиргааны албан хаагчдын албан хэрэг хөтлөлт, ажлын хавтаст сан үүсгэх мэдлэг дээшлүүлэх, компьютер эзэмших ур чадвар нэмэгдүүлэх, ажлын байр эмх цэгцтэй болгох зорилгоор “Цэвэр орчин-цэгцтэй ажлын байр” аянг 2017 оны 05 сарын 01-18-ны өдрүүдэд ХШҮДАГ-тай хамтран зохион байгуулав.

-2017 оны 01-06 сард давхардсан тоогоор 62 албан хаагч бялдаржуулах танхимаар үйлчлүүлж, лхагва, баасан гаригт спорт зааланд спортоор хичээллэж байна.

“Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 92.6 хувьтай үнэлэгдэв. Хөтөлбөрийн биелэлтийг тайланд хавсаргав.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны төрийн албан хаагчдын сургалтын 2017 оны төлөвлөгөөнд 13 үйл ажиллагаа тусган бүрэн хэрэгжүүлэв.

-2017 оны 01 сарын 12-ны өдөр Төрийн албаны зөвлөлтэй хамтран “Төрийн албаны шинэтгэл, хүний нөөцийн бодлого” сэдвээр аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газрын болон харьяа байгууллагуудын удирдах албан тушаалтнуудад зориулсан сургалт;

-2017 оны 01 сарын 24-ний өдөр Хууль зүйн яамтай хамтран “Хууль тогтоомжийн тухай хууль”-ийн танилцуулга сургалт;

-2017 оны 02 сарын 03-ны өдөр ЗГХЭГ, Сангийн яамтай хамтран “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам” танилцуулах сургалт;

-2017 оны 05 сарын 03-ны өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтран Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг танилцуулах сургалт;

-2017 оны 05 сарын 10-ны өдөр Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг /GIZ/-тэй хамтран Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх 4.0 системийн тухай;

- 2017 оны 05 сарын 22-ны өдөр Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран “Байгууллагын ногоон менежмент” сургалт;

- 2017 оны 10 сарын 25-ны өдөр Хууль сахиулахын их сургуулийн Хэвлэлийн редакцийн хэлтсийн дарга, доктор, Цагдаагийн хошууч С.Гантулгатай хамтран "Албан тушаалын гэмт хэргийн талаарх ойлголт, албан тушаалын гэмт хэрэг" сэдэвт сургалт;

-2017 оны 11 сарын 16-ны өдөр Удирдлагын академийн багш, доктор, дэд профессор Н.Цолмонтуяатай хамтран "Төрийн албан хаагчийн хариглааны ёс зүй" сэдэвт сургалт; 2017 оны 11 сарын 30-ны өдөр Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн багш, доктор Б.Жаргалтай хамтран “Стресс менежмент” сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулав. Гадаад улсад сургалт, семинар, хурал, уулзалт, танилцах аялалд давхардсан тоогоор 90 албан хаагч оролцож, туршлага судлан, мэдлэг чадвараа сайжруулсан байна.

Төрийн албан хаагчдын сургалтын 2017 оны биелэлт 100 хувьтай байв. Төлөвлөгөөний биелэлтийг тайланд хавсаргасан болно.

3. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

3.1 Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг тайлагнах үнэлгээ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичиг, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 11 дүгээр хүснэгтэд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг үндэслэн хийлээ. Яамны 2017 оны үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ **98.1** хувьтай дүгнэгдэв.

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	<p>Яамны www.mofa.gov.mn вэб хуудсыг үүсгэж, шинэ мэдээ, мэдээлэл, газар, агентлагуудын танилцуулга, ажлын тайлангаар байнга шинэчлэн баяжуулж байх - Яамны цахим хуудсыг 35 үзүүлэлтийн дагуу Авилгатай тэмцэх газрын яаманд ажиллах ажлын хэсэгт танилцуулахад 2 үзүүлэлтийг вэбэд байршуулаагүй 0 оноо, бусад үзүүлэлтүүд бүрэн байршуулсан оноо авч 93 хувьтай үнэлүүлсэн.</p> <p>- Яамны вэбэд 12 дугаар сарын 6-ны өдрийн байдлаар шинэ мэдээ 527, тендерийн урилга 58, ЗГ-ын тогтоол 5, Сайд, ТНБД-ын тушаал 6, статистикийн товхимол 11, мониторингийн тайлан 30, дотоод аудитын тайлан 7, бусад тайлан төлөвлөгөө 29, Улаанбаатар хотын гол нэрийн зарим барааны үнийн 48 мэдээ, хөдөө аж ахуйн биржийн 48 мэдээ, төслийн хэлэлцүүлэг 21 удаа тавигдсан байна.</p> <p>- Хүнсний хангамжийн өнөөгийн байдал, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний тэнцэл, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, экспортын дэлгэрэнгүй мэдээлэл, ОХУ, БНХАУ-д Монгол улсаас махан бүтээгдэхүүн экспортлох магадлан итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн мэдээллийг яамны веб сайтыг хүсний салбар хэсэгт шинээр оруулсан.</p> <p>- Засгийн газрын www.zasag.mn сайтад яамны үйл ажиллагааны чиглэл, бодлого, холбоо барих хаягийг шинэчлэж оруулсан.</p> <p>- Вэб хуудсыг шинэчлэн баяжуулахад шаардлагатай мэдээллийг мэдээлэл хариуцсан мэргэжилтнүүдээс авч салбарын зарим хэсгийн мэдээллийг шинэчилсэн. Төрийн байгууллагын стандартад нийцсэн байна.</p>	90
2	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	<p>Яамны http://mofa.gov.mn/exp/static/contact_us вэб хуудсын холбоо барих хэсэгт яамны газар, хэлтсийн мэргэжилтнүүдийн утасны дугаарын мэдээллийг оруулсан. Мөн холбоо барих И-мэйл: mofa@mofa.gov.mn, Вэб: mofa.gov.mn, Утас: 51-262271, Факс: 51-263237, Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот 13381, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IXа байр</p>	95
3	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	<p>Яамны http://mofa.gov.mn/exp/blog/43/93 вэб хуудсанд тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон тусгай зөвшөөрөл авсан аж ахуй нэгжийн мэдээллийг оруулсан.</p>	100
4	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль, тогтоомж, дүрэм журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	<p>Яамны http://mofa.gov.mn вэб хуудсын нүүр хэсэгт хууль, эрх зүй үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль, тогтоомж, дүрэм журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэж байна.</p>	100

5	Шинээр боловсруулж байгаа бодлогын барим бичиг болон захигааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах	Яамны http://mofa.gov.mn вэб хуудсын нүүрний доод хэсэгт шинээр боловсруулж байгаа бодлогын барим бичиг болон захигааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног байрлуулж саналыг хүлээн авч байна.	100
6	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Яамны вэбэд үйлчилгээ хэсэг оруулан тусгай зөвшөөрөл, салбарын шагнал авахад бүрдүүлэх баримт бичиг, түүний хураамж болон иргэдээс цахим хэлбэрээр өргөдөл, гомдол авах зэрэг мэдээллүүд оруулсан. Яамны вэбэд өргөдөл гомдол, санал, хүсэлт хариуцсан мэргэжилтний хаяг, яаманд хандаж цахим хэлбэрээр өргөдөл, гомдол гаргах зөвлөмж, өргөдөл, гомдол, санал хүсэлтийн улирал бүрийн мэдээг байрлуулан иргэдийн санал гомдлыг цахим хэлбэрээр авч байна. Цахим хэлбэрээр авсан санал гомдолд тухай бүр хариу илгээж ажилласан. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ авсан, сунгасан байгууллагын гэрчилгээний үнэ төлсөн жагсаалт	80
7	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухай төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх	Яамны харьяа байгууллагуудын холбоо барих цахим хуудас болон холбогдох утасны дугаарын хамт байршуулсан болно.	100
8	Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Яамны http://mofa.gov.mn/exp/blog/43/93 вэб хуудсанд тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон тусгай зөвшөөрөл авсан аж ахуй нэгжийн мэдээллийг оруулсан.	100

9	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр 5 хөтөлбөр, гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа 8 төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх хяналт-шинжилгээ үнэлгээний тайлангийн жилийн эцсийн байдлаар цахим хуудсандаа мэдээллийг байрлуулж байна.	100
Хэсгийн дундаж хувь:			96.1
Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал			
1	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах	Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн даргын ажлын байрны сул орон тоо, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Худалдаа, нийтийн хоол, үйлчилгээний зохицуулалтын хэлтсийн даргын ажлын байрны сул орон тоог тус тус нийтэд нээлттэй зарлаж, Төрийн албаны зөвлөлийн болон яамны цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулав. Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Сав, баглаа боодол, дахин боловсруулах болон барилгын материал үйлдвэрлэлийн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоог төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй иргэдээс нөхөх зарыг Төрийн албаны зөвлөлийн болон яамны цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулав.	100
2	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Яамны цахим хуудас www.mofa.gov.mn -ны “Хүний нөөц” буланд Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн тухай зөвлөмж, хичээл, сургалтын материалыг байрлуулснаар ёс зүйн тухай ойлголт, мэдээлэл авах боломж нөхцлөөр хангалаа. Мөн Ёс зүйн хорооны хуралдаанаар хэлэлцсэн асуудлын тоймыг байршуулав. Яамны цахим хуудасны “Хүний нөөц” буланд иргэдээс “Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлагын талаар санал, хүсэлт хүлээн авах” буланг ажиллуулж, байгууллагын 1 давхарт байрлах Авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах мэдээллийн самбарын дэргэд иргэдийн санал, хүсэлтийг хүлээж авах “Саналын хайрцаг” ажиллуулж байна.	100
3	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 126 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнг үнэлж, дүгнэх журам"-д заасны дагуу хүний нөөцийн стратеги, үйл ажиллагааг үнэлүүлж байна.	100
4	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны цахим хуудасны “Хүний нөөц” буланд Салбар зөвлөлтэй холбоотой шийдвэр, хууль, дүрэм, журам, 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлын тойм, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн асуудалтай холбоотой дүрэм, журам, сургалтын материал, зөвлөмж, гомдол санал хүлээн авах хэсэг, төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээтэй холбоотой мэдээлэл, ажлын байрны сул орон тоо, сонгон шалгаруулалтын дүн, төрийн жинхэнэ албан тушаалд анх орохтой холбоотой журмыг байршуулан албан хаагч болон иргэдэд мэдээллийг нээлттэй, ил тод түгээж ажиллаа. Яамны батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээг сар бүр http://www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулж байна. Мөн хүний нөөцийн асуудлаар гарсан тушаал, шийдвэрийг тухай бүр нь холбогдох албан хаагчдад танилцуулж, яамны дотоод сүлжээ АСУ программаар ажилд томилогдсон болон чөлөөлөгдсөн албан хаагчдын талаар мэдээлж байна.	100

5	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх	Яамны албан хаагчдын үр дүнгийн гэрээний биелэлтийн үнэлгээг хагас жилийн байдлаар Салбар зөвлөлийн 2017 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 05 дугаар хуралдаанаар хэлэлцэж, үр дүнгийн гэрээний биелэлтийн үнэлгээг харгалзан Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А-тушаал гарч, 113 албан хаагчид тус бүр 150 000 төгрөгийн урамшуулал олгож, Төрийн одон медальд 3 албан хаагчийг, Засгийн газрын хүндэт өргөмжлөл шагналд 1 албан хаагчийг тус тус тодорхойлсон. Салбар зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 06 дугаар хуралдаанаар албан хаагчдын үр дүнгийн гэрээний биелэлтийн үнэлгээг жилийн эцсийн байдлаар хэлэлцэж, үнэлгээг баталгаажуулав. Үр дүнгийн гэрээний үнэлгээний мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг хэлэлцэн “А” үнэлгээ авсан 27 албан хаагчид албан тушаалын цалингийн 60 хувьтай тэнцэх, “В” үнэлгээ авсан 66 албан хаагчид албан тушаалын цалингийн 40 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгов. Үр дүнгийн урамшуулалд нийт 30 000 000 төгрөг зарцуулсан байна. Мэргэжилтний үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх илтгэх хуудасны загвар, Төрийн албаны зөвлөлийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн хуралдаанаар албан хаагчдын үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэлсэн талаарх тойм болон холбогдох бусад мэдээллийг тухай бүр нь цахим хуудсанд байршуулж ажиллалаа.	100
Хэсгийн дундаж хувь:		100	
Хэрэгжилтийн дундаж хувь:		98.1	

3.2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичиг, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.10-д заасны дагуу Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргаж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх болно.

3.3. Шударга байдлын түвшний үнэлгээ

АТГ-аас байгууллагын авилгын эсрэг явуулж буй үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ тус яамны Авилгын эсрэг үйл ажиллагааны 2017 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг Авилгатай тэмцэх газарт хүргүүлсэн бөгөөд манай байгууллагын авилгын эсрэг явуулж буй үйл ажиллагаанд өгсөн үнэлгээний талаар албан ёсны мэдээ, мэдээлэл ирүүлээгүй тул яамны үйл ажиллагааны үнэлгээний дүнд оруулж тооцолгүй хассан болно.

3.4. Хэрэглэгчийн үнэлгээ

“Хэрэглэгчийн үнэлгээ хийх” зөвлөх үйлчилгээний тендерт гүйцэтгэгчээр “Улаанбаатар аудит корпораци” ХХК шалгарсан. Хэрэглэгчийн үнэлгээг төрийн бодлогын хэрэгжилт, төрийн байгууллагуудаас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэд, аж ахуйн нэгжүүдийг хамруулан явуулсан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогын хэрэгжилтийн талаарх хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ Дархан-Уул, Өвөрхангай, Өмнөговь, Увс аймаг, Улаанбаатар хотын Багануур, Баянгол, Сүхбаатар дүүргийн насанд хүрсэн 1801 хэрэглэгчийг хамруулсан. Үүнээс 24.5 % нь МАА-н салбарын, 22% нь газар тариалангийн, 23% хүнсний үйлдвэрийн, 7.5% хөнгөн үйлдвэрийн, 18% нь жижиг, дунд үйлдвэрийн салбарын хэрэглэгчийг түүвэр судалгаанд хамруулан асуулгын аргачлалыг ашигласны зэрэгцээ асуулгын хариултыг 1-5 баллаар үнэлж, дүгнэлт гаргав.

№	Салбар	Дундаж үнэлгээ	
		%	оноо
1	Мал, аж ахуйн салбар	90	4.5
2	Газар тариалангийн салбар	88	4.4
3	Хүнсний салбар	85	4.2
4	Жижиг, дунд үйлдвэрийн салбар	85	4.2
5	Хөнгөн үйлдвэрийн салбар	86	4.3
Ерөнхий үнэлгээ		86.8	4.3

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хэрэглэгчийн үнэлгээний энэ удаагийн судалгаанд хамрагдсан нийт хэрэглэгчийн үнэлгээг нэгтгэж салбарын ерөнхий үнэлгээ 86.8 хувьтай гарч байна. Хэрэглэгчийн үнэлгээний тайланг хавсралтаар хүргүүлсэн болно.

4. ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	81,7	0.6	
	2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	98.8		
	3.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт	73.3		
	4.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	89.5		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1.Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	68.5	0.2	
	2.Байгууллагын хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажилуулах талаарх тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан зорилтын биелэлт	96.3		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	96.3	0.2	
	2. Шилэн дансны хөтөлөлтийн үнэлгээ	-		
	3. Шударга байдлын түвшний үнэлгээ	-		
	4. Хэрэглэгчийн үнэлгээ	86.8		
Ерөнхий үнэлгээ		86.3		4.3

5. ДҮГНЭЛТ

5.1 Хүнс, хөдөө аж ахуйн яамны 2016 оны үйл ажиллагааны үнэлгээний дүн Бодлогын зорилтын хэрэгжилт, Байгууллагын чиг үүргийн үзүүлэлт, байгууллагын нээлттэй байдал, Үйл ажиллагааны үр дүнг багцалсан үзүүлэлтээр **86.3** хувийн үнэлгээтэй буюу **4.3** гэсэн оноотой гарч байна. Бодлогын зорилтын хэрэгжилтийн үнэлгээний дундаж **85.8** хувь, байгууллагын чиг үүргийн үзүүлэлт үнэлгээний дундаж **82.4** хувь, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээний дундаж **91.55 хувь** тус тус үнэлэгдсэн.

5.2 Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Хүнс, хөдөө аж ахуйн салбарын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг 2017 оны жилийн эцсийн байдлаар үнэлж үзэхэд хэрэгжилт дунджаар 37.05 хувь буюу хүрвэл зохих түвшингийн үнэлгээ 98.8 хувь биелэгдсэн байна. Тухайлбал 5 арга хэмжээ 100 хувь, 29 арга хэмжээ 70 хувь, 72 арга хэмжээ 40 хувь, 40 арга хэмжээ “0” хувийн биелэлттэй байна. Үүнээс гадна 18 арга хэмжээг үнэлэх боломжгүй байна. Үнэлэх боломжгүй арга хэмжээнүүд нь яамны төлөвлөгөө батлагдсанаас хойш хяналтад авсан, төсөв хөрөнгө тодорхойгүй, гүйцэтгэлийг үнэлэхэд хангалттай мэдээлэл байхгүй зэрэг гадаад хүчин зүйлээс хамаарсан шалтгаантай байв.

5.3 “Хэрэглэгчийн үнэлгээ хийх” зөвлөх үйлчилгээ гүйцэтгэсэн “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн судалгааны үр дүнгээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хэрэглэгчийн ерөнхий үнэлгээ **86.8** хувьтай байгаа нь салбарын хэрэглэгчдийн сэтгэл ханамж өндөр байгааг илтгэж байна.

6. ЗӨВЛӨМЖ

6.1. Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэхдээ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлттэй цаг хугацааны хувьд зэрэг хийх, үйл ажиллагааны үр дүнг хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнтэй уялдуулан дүгнэж байхыг төрийн захиргааны удирдлагын газарт;

6.2. ХХААХҮЯ-ны 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 68.7 хувьтай гарсан нь хангалттай үнэлгээ биш бөгөөд дундаж дүн нь 70 хувиас доош үнэлэгдсэн нэгжүүд үйл ажиллагаандаа дүгнэлт хийж, цаашид зорилтоо тусгахдаа цаг хугацаа, хөрөнгө санхүү, хүний болон дотоод нөөц бололцоогоо тооцоолон зөв тодорхойлох, тавьсан зорилтын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаж байхыг бүх газар хэлтэст;

6.3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны А-159 дүгээр тушаалаар баталсан “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-д заасныг баримтлан тогтоосон цаг хугацаанд, зохих шаардлагад нийцүүлэн, тайлагийн чанарыг дээшлүүлэн тайлагнаж байхыг бүх газар хэлтэст тус тус зөвлөж байна.